



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/036/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 70363040 Цахим хаяг: batmunkhb @audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 70363036 Цахим хаяг: otgonbayarts@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: “Мэдээлэл аудит” ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

Г МАНДАЛ СУМЫН НЭГДҮГЭЭР Г  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Л.БҮРЭНЖАРГАЛ ТАНАА

2026.02.25 № СЭА-2026/036/НА-СТА-ТШЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын нэгдүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас 2,167.6 мянган төгрөгийн урамшууллыг тогтоосон хувь хэмжээнээс илүү бодож олгосон,
- Амралттай хугацаанд буюу 8 дугаар сард 193.0 мянган төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилласны нэмэгдэл хөлс бодож олгосон,
- Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 3,412.5 мянган төгрөгийн цалинг давхардуулан бодож олгосон,

- Тооцоо нийлж баталгаажуулаагүйн улмаас төлбөр 7,673.9 мянган төгрөгийг илүү шилжүүлж, 4,895.6 мянган төгрөгийн хүнсний материалыг шаардлагагүйгээр их хэмжээгээр нөөцөлсөн,

Аудитаар илэрсэн дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2017 оны А/376, А/217/366 дугаар “Журамд өөрчлөлт оруулах тухай” тушаалын 1 дэх хавсралт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/430 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Мандал сумын нэгдүгээр цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/228 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 3 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 15,176.2 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус цэцэрлэг нь 2025 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 10 зорилтын хүрээнд 55 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 91.7 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Тод-руулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4	167,326,683.06	31,699,036.06
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		167,326,683.06	31,699,036.06
3121	Төгрөг		167,326,683.06	31,699,036.06
31211	Төрийн сангийн харилцах		167,326,683.06	31,699,036.06
35	БАРАА МАТЕРИАЛ	6	8,342,476.00	10,496,540.00
354	Хангамжийн материал		8,342,476.00	10,496,540.00
3546	Хүнсний материал		6,041,576.00	4,895,640.00
3547	Бусад хангамжийн материал		2,300,900.00	5,600,900.00
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		175,669,159.06	42,195,576.06
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	677,796,646.43	694,880,453.70
392	Биет хөрөнгө		460,970,896.43	478,179,703.88
39201	Барилга, байгууламж, орон сууц		520,665,518.05	521,865,518.05
39202	Хуримтлагдсан элэгдэл		(148,471,152.48)	(172,622,217.93)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)		46,958,648.64	43,352,886.84
39206	Хуримтлагдсан элэгдэл		(26,900,901.25)	(19,186,424.70)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		36,855,391.90	59,899,753.70
39208	Хуримтлагдсан элэгдэл		(14,950,961.43)	(9,983,365.16)
39214	Бусад үндсэн хөрөнгө		80,786,053.00	88,757,417.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(34,014,700.00)	(33,946,863.92)
39217	Ном		43,000.00	43,000.00
393	Биет бус хөрөнгө		216,825,750.00	216,700,749.82
39301	Програм хангамж		1,625,000.00	1,625,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл		(431,250.00)	(556,250.18)
39303	Бусад биет бус хөрөнгө		215,632,000.00	215,632,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		677,796,646.43	694,880,453.70
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		853,465,805.49	737,076,029.76
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9	2,894,340.02	7,452,768.08
413	Өглөг		2,894,340.02	7,452,768.08
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		2,894,340.02	7,452,768.08
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		2,894,340.02	7,452,768.08
51	Засгийн газрын хувь оролцоо		850,571,465.47	729,623,261.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		332,071,103.00	332,071,103.00
51101	Өмч: - төрийн		332,071,103.00	332,071,103.00
512	Хуримтлагдсан үр дүн		(35,080,333.18)	(146,876,147.89)
5121	Өмнөх үеийн үр дүн		(35,080,333.18)	(29,093,974.30)
5122	Тайлант үеийн үр дүн			(117,782,173.59)
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		553,580,695.65	544,428,306.57
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		850,571,465.47	729,623,261.68
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		853,465,805.49	737,076,029.76

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,324,959,310.98	1,473,680,548.51
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		1,251,768,800.00	1,392,339,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,251,768,800.00	1,392,339,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		73,190,510.98	81,341,448.51
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		73,190,510.98	81,341,448.51
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО			55,516,356.64
120	Нийтлэг татварын бус орлого			55,516,356.64
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө			55,516,356.64
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2	1,324,959,310.98	1,529,196,905.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,312,677,768.23	1,646,979,078.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,301,366,668.23	1,637,114,578.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		905,250,636.70	1,187,059,859.98
210101	Үндсэн цалин		538,217,190.25	639,975,931.31
210102	Нэмэгдэл		338,073,001.45	467,851,760.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт			29,695,459.79
210104	Урамшуулал		28,960,445.00	49,536,708.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		112,854,460.35	155,487,268.08
210201	Тэтгэврийн даатгал		80,067,445.71	100,421,800.00
210202	Тэтгэмжийн даатгал		9,079,218.34	11,903,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		4,647,807.18	5,951,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал		3,847,295.60	5,951,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал		15,212,693.52	31,259,068.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		54,646,510.98	51,171,198.51
210301	Гэрэл, цахилгаан		8,198,164.15	11,148,189.65
210302	Түлш, халаалт		33,524,875.01	31,160,335.98
210303	Цэвэр, бохир ус		12,923,471.82	8,862,672.88
2105	Нормативт зардал		123,257,228.80	133,298,433.00
210502	Хоол, хүнс		123,257,228.80	133,298,433.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		18,544,000.00	30,170,250.00
210604	Урсгал засвар		18,544,000.00	30,170,250.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,744,900.00	6,938,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		3,744,900.00	6,938,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		83,068,931.40	72,988,669.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		32,276,100.00	24,242,550.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		10,944,300.00	10,341,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		39,848,531.40	38,405,119.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		11,311,100.00	9,864,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		11,311,100.00	9,864,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		11,311,100.00	9,864,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	1,312,677,768.23	1,646,979,078.74
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)		12,281,542.75	(117,782,173.59)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)			
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)		12,281,542.75	(117,782,173.59)

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,324,959,310.98	1,473,680,548.51
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,324,959,310.98	1,473,680,548.51
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,251,768,800.00	1,392,339,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,251,768,800.00	1,392,339,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	73,190,510.98	81,341,448.51
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	73,190,510.98	81,341,448.51
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,276,589,202.01	1,609,308,195.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,276,589,202.01	1,609,308,195.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,265,278,102.01	1,599,443,695.51
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	905,250,636.70	1,189,954,200.00
210101	Үндсэн цалин	538,217,190.25	642,870,271.33
210102	Нэмэгдэл	338,073,001.45	467,851,760.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт		29,695,459.79
210104	Урамшуулал	28,960,445.00	49,536,708.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,960,120.33	148,034,500.00
210201	Тэтгэврийн даатгал	77,173,105.69	100,421,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,079,218.34	11,903,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,647,807.18	5,951,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,847,295.60	5,951,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,212,693.52	23,806,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,646,510.98	51,171,198.51
210301	Гэрэл, цахилгаан	8,198,164.15	11,148,189.65
210302	Түлш, халаалт	33,524,875.01	31,160,335.98
210303	Цэвэр, бохир ус	12,923,471.82	8,862,672.88
2105	Нормативт зардал	127,610,634.00	132,152,497.00
210502	Хоол, хүнс	127,610,634.00	132,152,497.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,544,000.00	30,170,250.00
210604	Урсгал засвар	18,544,000.00	30,170,250.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,744,900.00	6,938,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,744,900.00	6,938,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,521,300.00	41,022,150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,577,000.00	30,681,150.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,944,300.00	10,341,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,311,100.00	9,864,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,311,100.00	9,864,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,311,100.00	9,864,500.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	48,370,108.97	(135,627,647.00)
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	48,370,108.97	(135,627,647.00)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		167,326,683.06
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		31,699,036.06

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	332,071,103.00	553,580,695.65	(35,080,333.18)	850,571,465.47
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			5,986,358.88	5,986,358.88
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		(9,152,389.08)		(9,152,389.08)
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн			(117,782,173.59)	(117,782,173.59)
19	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	332,071,103.00	544,428,306.57	(146,876,147.89)	729,623,261.68

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	1,646,365,500.00	1,473,680,548.51	172,684,951.49	89.5
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,554,789,800.00	1,392,339,100.00	162,450,700.00	89.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,400,847,300.00	1,392,339,100.00	8,508,200.00	99.4
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	153,942,500.00			
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	91,575,700.00	81,341,448.51	10,234,251.49	88.8
132001	Орон нутгийн төсвөөс	91,575,700.00	81,341,448.51	10,234,251.49	88.8
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,646,365,500.00	1,473,680,548.51	172,684,951.49	89.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,646,365,500.00	1,609,308,195.51	37,057,304.49	97.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,636,501,000.00	1,599,443,695.51	37,057,304.49	97.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,194,768,700.00	1,189,954,200.00	4,814,500.00	99.6
210101	Үндсэн цалин	747,101,400.00	642,870,271.33	104,231,128.67	86.0
210102	Нэмэгдэл	402,945,800.00	467,851,760.58	(64,905,960.58)	116.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт		29,695,459.79	(29,695,459.79)	
210104	Урамшуулал	44,721,500.00	49,536,708.30	(4,815,208.30)	110.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	148,034,500.00	148,034,500.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	100,421,800.00	100,421,800.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	11,903,200.00	11,903,200.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,951,600.00	5,951,600.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	5,951,600.00	5,951,600.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	23,806,300.00	23,806,300.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,404,900.00	51,171,198.51	10,233,701.49	83.3
210301	Гэрэл, цахилгаан	14,482,600.00	11,148,189.65	3,334,410.35	77.0
210302	Түлш, халаалт	34,400,000.00	31,160,335.98	3,239,664.02	90.6
210303	Цэвэр, бохир ус	12,522,300.00	8,862,672.88	3,659,627.12	70.8
2105	Нормативт зардал	154,068,000.00	132,152,497.00	21,915,503.00	85.8
210502	Хоол, хүнс	154,068,000.00	132,152,497.00	21,915,503.00	85.8

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,170,800.00	30,170,250.00	550.00	100.0
210604	Урсгал засвар	30,170,800.00	30,170,250.00	550.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,939,000.00	6,938,900.00	100.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,939,000.00	6,938,900.00	100.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,115,100.00	41,022,150.00	92,950.00	99.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,774,100.00	30,681,150.00	92,950.00	99.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,341,000.00	10,341,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,864,500.00	9,864,500.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,864,500.00	9,864,500.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,864,500.00	9,864,500.00	-	100.0
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,646,365,500.00	1,609,308,195.51	37,057,304.49	97.7
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		167,326,683.06	(167,326,683.06)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		31,699,036.06	(31,699,036.06)	
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО				
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ				

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 31,670.0 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- *Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 29 нэр төрлийн 31,670.0 мянган төгрөгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй.*

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд УСНББОУС-17 “*Үндсэн хөрөнгө*”-ийн ХЗУ<sup>1</sup>4-д “*... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй ...*”, санхүүгийн тайлангийн “*Үнэлгээ ба хуваарилалт*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт **82,687.4** мянган төгрөгийн 8 зөрчил<sup>2</sup> илэрснээс 10,034.5 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт, 8,308.1 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 64,344.8 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **18,342.6** мянган төгрөгийн материаллаг залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5,215.8 мянган төгрөгөөр давсан тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

<sup>1</sup> ХЗУ-Хэрэгжүүлэх заавар удирдамж

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### **3.1 Төлбөрийн акт**

1. Төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр шаардлага хангасан 11 багшид 2,167.6 мянган төгрөгийн урамшууллыг тогтоосон хувь хэмжээнээс илүү бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”*, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/430 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.4 *“...багшийн ажлын үнэлгээний үр дүнд үндэслэн багшид Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолд заасан мөнгөн урамшууллыг ... хувь хэмжээгээр албан тушаалын сарын үндсэн цалингаас тооцож олгоно”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Улирлын амралттай хугацаанд бус 8 дугаар сард арга зүйч Д.Энхчимэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилласны нэмэгдэл хөлс 193.0 мянган төгрөгийг бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2017 оны А/376, А/217/366 дугаар *“Журамд өөрчлөлт оруулах тухай”* тушаалын 1 дэх *“Сурагчийн улирлын амралт болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас ерөнхий боловсролын сургууль, сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон боловч багш үндсэн ажлаа гүйцэтгэж байгаа тохиолдолд багшид албан тушаалын үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс урамшил олгоно”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

3. Нягтлан бодогч С.Оюун-Эрдэнэ нь Шанзан ташуур ХХК-тай тооцоо нийлж, баталгаажуулаагүйгээс 7,673.9 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”*, гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү шилжүүлсэн төлбөрийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### **3.2 Албан шаардлага**

1. Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 3 ажилтанд 3,412.5 мянган төгрөгийн цалинг давхардуулан бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”*, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх *“Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Биеэр бүрэн эдлээгүй ээлжийн амралтыг нөхөн эдлүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

2. Хоол, хүнсний зардлын хэмнэлтээс 4,895.6 мянган төгрөгийн хүнсний материал нөөцөлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь “... шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Биет бус хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Тухайн байгууллагын эзэмшилд буй 1 газрын хэмжээ нь газрын гэрчилгээнд 13364 м<sup>2</sup> гэж бүртгэгдсэн боловч санхүүгийн тайланд 16900 м<sup>2</sup> буюу зөрүүтэй бүртгэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалтыг зөрчиж, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Биет бус хөрөнгийг бүртгэл тайланд бүрэн, зөв дүнгээр тусгаж байх зөвлөмж хүргүүллээ.

1.2 Илрүүлэлт: Гүйлгээ баланс дахь хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлийн дүн нь үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангаас 20,036.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийг бүртгэл тайланд бүрэн, зөв дүнгээр тусгаж байх зөвлөмж хүргүүллээ.

1.3 Илрүүлэлт: Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй бэлтгэсэн 44,308.6 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5-д “бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Үнэ төлбөргүй бараа материалыг бүртгэл тайланд бүрэн, зөв дүнгээр тусгаж байх зөвлөмж хүргүүлээ

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## **ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

### **Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийг дансанд бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй	1	31,670.0	1	31,670.0			1	31,670.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>31,670.0</b>	<b>1</b>	<b>31,670.0</b>			<b>1</b>	<b>31,670.0</b>				

### **Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тогтоосон хувь хэмжээнээс илүү цалинг бодож олгосон	1	2,167.6	1	2,167.6								
Амралттай үед хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилласны нэмэгдэл хөлс бодож олгосон	1	193.0	1	193.0								
Тооцоо нийлж баталгаажуулаагүйгээс илүү шилжүүлсэн	1	7,673.9	1	7,673.9								
Ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс цалинг давхардуулан бодож олгосон	1	3,412.5			1	3,412.5						

Биет бус хөрөнгийг зөв дүнгээр тусгаагүй	1	-					1	-				
Элэгдлийн эхний үлдэгдэл зөрүүтэй илэрхийлэгдсэн	1	20,036.3					1	20,036.3				
Үнэ төлбөргүй орлогыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй	1	44,308.6					1	44,308.6				
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>77,791.8</b>	<b>3</b>	<b>10,034.5</b>	<b>1</b>	<b>3,412.5</b>	<b>3</b>	<b>64,344.8</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Хүнсний материалыг шаардлагагүйгээр нөөцөлсөн	1	4,895.6			1	4,895.6		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>4,895.6</b>			<b>1</b>	<b>4,895.6</b>		
<b>Нийт дүн</b>								

### ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		